

**ХЭРЛЭН ГОЛЫГ БОХИРДОЛТ, ШИРГЭЛТЭЭС ХАМГААЛАХ, УРСЦЫГ САЙЖРУУЛАХ  
АЖЛЫН ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ**

Улаанбаатар хот  
2024.07.01

1	Ажил гүйцэтгэх үндэслэл	<ul style="list-style-type: none"><li>➢ Монгол Улсын Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 4.2.4 дэх хэсэг;</li><li>➢ Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал 2030-ийн 2.3 дахь хэсэг;</li><li>➢ Монгол Улсын Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн 5.1.12 дахь заалт;</li><li>➢ Монгол улсын 2024 оны төсвийн тухай хуулийн 2 дугаар хавсралт</li><li>➢ Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2023 оны 12 дугаар сарын 26-ны өдрийн А/641 тушаал;</li><li>➢ Засгийн газрын хэрэгжүүлэгч Агентлаг Усны газрын даргын 2024 оны А/02 тушаал</li><li>➢ Монгол Улсын уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох төлөвлөгөө.</li></ul>
2	Зорилго:	Хэрлэн голын урсцыг сайжруулах, цутгал голуудыг сэргээх, бохирдлоос хамгаалах цогц ажлыг хэрэгжүүлэх, гол хамгааллын жишиг ажил хийх.
3	Хөрөнгө оруулалтын эх үүсвэр:	Улсын төсвийн хөрөнгө оруулалт
4	Санхүүжилтийн хуваарь:	Нийт 3,000.0 сая төгрөг Үүнээс 2024 онд: 900.000 сая төгрөг 2025 онд: 1 700.0 сая төгрөг 2026 онд: 400.000 сая төгрөг
5	Захиалагч байгууллага:	Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Усны газар
6	Хамрах хүрээ:	Хэрлэн голын эхээс адаг хүртэл (Хэрлэн голын сав газар)
7	Төсөл хэрэгжүүлэх хугацаа:	Эхлэх хугацаа: 2024 оны 08 дугаар сарын 01-ний өдөр Дуусах хугацаа: 2026 оны 08 дугаар сарын 15-ны өдөр хүртэл
8	Гүйцэтгэх ажлууд:	<b>БАГЦ-1 ХЭРЛЭН ГОЛЫН УРСЦЫГ САЙЖРУУЛАХ, ЦУТГАЛ ГОЛУУДЫГ СЭРГЭЭХ АЖИЛ</b>  2024 онд 500 сая.төг 2025 онд 900 сая.төг 2026 онд 200 сая.төг  1.1 Хэрлэн голын цутгал болох Цэнхэр, Мөрөн, Тэнүүн голуудыг Хэрлэн голд байнгын нийлэх боломжийг бүрдүүлэх 1.2 Цутгал голуудын урсцыг сайжруулах, Хэрлэн голд нийлэх ажлын техникийн шийдэл, тооцоо судалгаа, зураг төсвийг боловсруулж, барилга байгууламжийг барих 1.3 Батлагдсан ажлын зураг дээр үндэслэн төсвийн дагуу Хэрлэн голын цутгал голууд болох Цэнхэр, Мөрөн, Тэнүүн гол урсцыг сэргээж, Хэрлэн голд хүргэх ажлыг хэрэгжүүлэх

1.4 Тус ажлыг хэрэгжүүлэхэд шаардагдах цутгал голын горимын судалгаа, тооцоог хийх, голын төлөв байдлыг үнэлж, дүгнэх

1.5 Барилга байгууламжийн зохистой ашиглалтыг хэрэгжүүлэх менежментийн төлөвлөгөөг боловсруулах

### **БАГЦ-2 ХЭРЛЭН ГОЛЫН САВ ГАЗРЫН НУУРУУДЫГ СЭРГЭЭХ АЖИЛ**

2024 онд 300 сая

2025 онд 650 сая.төг

2026 онд 200 сая.төг

2.1 Шорвог, Хоёр Мэлхийт зэрэг татмын нууруудыг сэргээх замаар Хэрлэн голын урсацыг сайжруулах, уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох ажлыг хэрэгжүүлэх

2.2 Нуурыг сэргээх ажлын техникийн шийдэл, тооцоо судалгаа, зураг төсвийг боловсруулж, барилга байгууламжийг барих

2.3 Батлагдсан зураг, төсвийн дагуу Хэрлэн голын татмын нуурууд болох Шорвог, Хоёр Мэлхийт нуурыг сэргээх

2.4 Нуурын зохистой ашиглалт, хамгаалалтын санал боловсруулах

### **БАГЦ-3 ХЭРЛЭН ГОЛЫН САВ ГАЗРЫН УСНЫ НӨӨЦИЙГ ЗОХИСТОЙ АШИГЛАХ, ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭГ ТӨЛӨВЛӨХ АЖИЛ**

2024 онд 100 сая

2025 онд 150 сая

3.1. Хэрлэн голын сав газрын усны нөөц, ус ашиглалтын өнөөгийн байдал, хэтийн төлөв, усны аж ахуйн баланс, усны нөөцийг зохистой ашиглах, хамгаалах арга замыг тогтоох

3.2 Сав газрын хэмжээнд хийгдэж байсан усны чанар, бохирдлын судалгааг нэгтгэж, Хэрлэн голын бохирдлыг бууруулах арга хэмжээ, зөвлөмжийг боловсруулахад зориулж усны дээж авах тоо, байршил цэгүүдийг төлөвлөн гүйцэтгэх

3.3 Усны дээж цуглуулж усны чанарын үнэлгээг лабораторийн үр дүнд суурилан үнэлж, бохирдуулагч эх үүсвэрүүдийг тодорхойлох, тэдгээрийг бууруулах арга хэмжээг авах, Хэрлэн голын сав газар цаашид авах арга хэмжээг тусгасан бохирдлыг бууруулах төлөвлөгөөг эцэслэн боловсруулах

3.4 Сав газрын хэмжээнд одоо байгаа гадаргын болон газрын доорх усны харуул мониторингийн цэгүүдтэй танилцаж багаж тоног төхөөрөмжийн гүйцэтгэлийг шалгаж мониторингийн цэгүүдийг байгуулах тохиромжтой газруудыг товлон газрын доорх усны хяналт-мониторингийн 2 цэг шинээр байгуулж, сүлжээнд холбох, гадаргын усны хяналт-мониторингийн 2 цэг шинээр байгуулж сүлжээг өргөтгөх.

9	Гүйцэтгэх ажил, түүнд тавигдах ерөнхий шаардлагууд:	<ol style="list-style-type: none"> <li>1. Гэрээнд тусгагдсан бүх ажлыг Байгаль орчныг хамгаалах тухай хууль, Усны тухай хууль болон Монгол улсад мөрдөж буй хууль тогтоомж, стандартын дагуу хийж гүйцэтгэх;</li> <li>2. Ажлын нарийвчилсан төлөвлөгөөг Усны газраар батлуулах;</li> <li>3. Гүйцэтгэгч нь техникийн даалгаврын дагуу ажлыг чанарын өндөр түвшинд, гэрээний хугацаанд багтаан гүйцэтгэнэ;</li> <li>4. Гүйцэтгэгч нь гэрээнд заасан ажил тус бүрийг фото зураг, далд ажлын актаар баталгаажуулан холбогдох тайлан мэдээллийг тайланд хавсаргах;</li> <li>5. Байгалийн давагдашгүй хүчин зүйл (гамшиг, гал түймэр, үер)-ээс сэргийлэн аюулгүй байдлыг бүрэн хангаж ажиллах ба хэрэв ямар нэгэн арга хэмжээгүй авалгүй гэнэтийн гамшигт өртвөл гүйцэтгэгч хариуцна;</li> <li>6. Гүйцэтгэгч нь хөдөлмөр хамгаалал, техникийн аюулгүй ажиллагааны нөхцөлийг бүрэн хангаж, үүнээс гарах хор хохирлыг өөрсдөө хариуцна;</li> <li>7. Баталгаат хугацаанд гарсан гэмтлийг өөрийн хөрөнгөөр захиалагчийн заасан хугацаанд засварлаж өгнө.</li> <li>8. Ажлын графикт хугацаанд бүрэн гүйцэтгэж Улсын комиссоор байнгын ашиглалтад хүлээлгэн өгнө.</li> </ol>
10	Гүйцэтгэх байгууллагад тавигдах ерөнхий шаардлагууд:	<ul style="list-style-type: none"> <li>- Усны мэргэжлийн байгууллагын тусгай зөвшөөрөлтэй.</li> <li>- Гүйцэтгэгч нь тухайн чиглэлээр мэргэшсэн, тухайн салбарт 3-аас доошгүй жил ажилласан туршлагатай,</li> <li>- Гүйцэтгэгч байгууллагын багийн ахлагч нь 10-аас доошгүй жилийн туршлагатай, багийн бүрэлдэхүүний гуравны хоёроос доошгүй нь мэргэжлийн боловсон хүчин байх;</li> <li>- Гүйцэтгэгч байгууллага нь хэмжилт, судалгааны багаж хэрэгсэл, тоног төхөөрөмжтэй байх;</li> <li>- Гүйцэтгэгч байгууллага нь барилга угсралтын ажлыг гүйцэтгэхэд зайлшгүй шаардлагатай үндсэн болон түрээсийн тоног төхөөрөмж, машин механизмуудтай байх.</li> </ul>
11	Баримт бичгийн иж бүрдэл	<ul style="list-style-type: none"> <li>- Ажлын эхлэлийн тайлан, төлөвлөгөөг гэрээ байгуулснаас хойш 1 сар, явцын тайланг ажил эхэлснээс хойш 2 сарын хугацаанд ирүүлсэн байх</li> <li>- Гүйцэтгэлийн тайланг 2024 оны 10 дугаар сарын 30-нд холбогдох газруудаар хэлэлцүүлж, хүлээлгэн өгсөн байх.</li> <li>- Тайлан бичмэл болон цахим хэлбэрээс гадна Баримт бичиг, ажлын зураг, төсвийг өнгөтөөр *.pdf форматаар 300 dpi нягтралтай сканердаж cd-нд хавсаргах</li> <li>- Тус ажлын явц үр дүнгийн 5 минутын дүрсжүүлсэн тайлан.</li> </ul>
12	Үр дүнг тайлагнах	Үр дүнг Усны нөөцийн зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэн батлуулах.

## УСНЫ ГАЗАР